

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
07 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2023.07.26

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Иргэдэд төрийн албаны мэдээлэл, төрийн үйлчилгээ хүргэх багийн өдөрлөгүүдийг 5 багийн төвд зохион байгуулсан.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Төсвийн хэмнэлтийн хуулийн хүрээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын 90 хувийн тендерийг зарласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны үйл ажиллагаанд жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийлгэхэд бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Сумын санхүүгийн 2023 оны эхний хагас жилийн тайланг гаргасан.

2024 оны төсвийн төсөөллийг хийгдэж байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

7 дугаар сарын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь гаргаж төрийн сангийн хэлтэст явуулсан.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг төрийн мэдээллийн үйлчилгээний цахим системд байршуулсан.

Хог хаягдалын тухай хууль, байгаль орчныг бохирдолоос хамгаалах сурталчилгааг иргэдэд 3 удаа цахимаар хүргэсэн./видео шторк/

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Сумын уурын зуухны шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Дорнын элч” ХХК нь ажлаа 08 дугаар сарын 10-ны дотор багтаан хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна./300,000,000 төгрөгийн төсөв ОНХС-ийн зардлаас/

Малжуулах төсөлд 3 өрхийг хамруулж 15,000,000 төгрөгийн мал олгож, ажлын байрыг нэмэгдүүлсэн.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг ландфилл технологиор цэгцлэх ажлыг “Аз Ок”, Шаргын хурд ХХК-иар гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэлийн явц 80 хувьтай байна./50.000.000 төгрөгийн төсөв байгаль хамгаалах зардлаас/

Хавиргын булгийн хөлд Хиймэл нуур байгуулах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулан, гэрээ байгуулсан./50.000.000 төгрөгийн төсөв байгаль хамгаалах зардлаас/

Сумын төвөөс 5 километр дотор нутаглаж байгаа малчин өрхүүдэд 8 сарын 01-ний дотор бэлчээр чөлөөлөх, мөн хөдөөгийн багийн өрхүүдийг бэлчээр чөлөөлүүлэх хугацаатай мэдэгдэл өгч, хяналт тавьж ажиллаж байна.

“Сүүж” нуурын усны ундаргыг сэргээх, хамгаалах, нөхөн сэргээх техникийн шийдлийг боловсруулах гидерогелогийн судалгааны ажлыг гүйцэтгэх төслийн багтай гэрээ байгуулж, төслийн багаас сургалт мэдээллийг хүргэх ажил зохион байгуулагдсан.

Албан байгууллага, ААН, өрхөөс 2023 оны хог хаягдалын хураамжийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж байна.

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ